

БАТЛАВ: ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗРЫН ДАРГА Ш.НОХОЙЖАВ

**НЭВТ РАШААН АМРАЛТЫН ГАЗАРТ ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ, ГАЛ ТОГООНЫ  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ, УРСГАЛ ЗАСВАР, ӨРГӨТГӨЛ ХИЙХ**

Тендер  
шалгаруулалт/  
гэрээний нэр,  
дугаар:

*Нэвт рашаан амралтын газарт зөөлөн эдлэл, гал  
тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх, урсгал  
засвар, өргөтгөл хийх ХОАОНӨГ/201912026*

Ховд хот  
2019 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газар** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Нэвт рашаан амралтын газар зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх, урсгал засвар, өргөтгөл хийх** тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 10 цаг 00 минут, Улаанбаатар хотын цагаар 11 цаг 00 минут**-аас өмнө **www.tender.gov.mn системээр дамжуулан цахимаар** ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 10 цаг 30 минут, Улаанбаатар хотын цагаар 11 цаг 30 минут**-д нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх.<sup>1</sup> **Үгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар, 4 давхар 407 тоот  
Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн Г.Нэмэхбаяр  
Утас: 70434401, Вэб: www.tender.gov.mn**

---

<sup>1</sup> Захиалагч тендер шалгаруулалтад давуу эрхийн зөрүү хэрэглэхгүй бол, энэ өгүүлбэрийг хасч оронд нь “Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй” гэж бичнэ.

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тогтмол үнэ**
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
  - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
  - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
  - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ  
байгуулах эрх  
олгох тухай  
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх</p> <p>Сүүлийн 2 жилийн буюу 2017, 2018 оны ижил төстэй ажлын туршлагын мэдээлэл, хийж гүйцэтгэсэн ажлын гэрээ, хүлээлгэн өгсөн акт.</p> <p>Бусад нэмэлт шаардлага;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар</li> <li>- Нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхойлолт багц тус бүрд ирүүлэх бөгөөд 1-р багцад тендер ирүүлж буй оролцогч 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар Барилгын инженер, ХАБЭА-н ажилтны нийгмийн даатгал төлсөн тодорхойлолт тооцооны хуудсын хамт ирүүлэх</li> <li>- Шүүх эрх бүхий байгууллагын тодорхойлолт</li> <li>- Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд тендерт оролцогчийн татварын өрийн мэдээллийг системээс шууд татаж үнэлэх тул татварын өргүй байх шаардлагатайг анхаарах</li> <li>- Харилцагч банкны мэдэгдэл</li> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.4-д заасны дагуу давуу эрхийн зөрүү тооцно. Мөн 10<sup>1</sup>.1.-д заасныг тендерийн үнэлгээнд харгалзан үзнэ.</li> </ul> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: 1-р багцад тендер ирүүлж буй оролцогч Барилга, хот байгуулалтын яамны тусгай зөвшөөрөл олгох ажлын төрөл, суурь нөхцөл, шаардлагын</p> <ul style="list-style-type: none"> <li>- БА-2.1-д заасан Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил</li> </ul>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> Давхар болон өрөөний дугаар:</p> <p>Огноо: 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр</p> <p>Цаг: Орон нутгийн цагаар 10 цаг 00 минут, Улаанбаатар хотын цагаар 11 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 4 давхар 415 тоот</p> <p>Огноо: 2019 оны 04 дүгээр сарын 12-ний өдөр</p> <p>Цаг: Орон нутгийн цагаар 10 цаг 30 минут, Улаанбаатар хотын</p>

	<b>цагаар 11 цаг 30 минут</b>
<b>ТӨӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <ul style="list-style-type: none"><li>• <b>Нэгдүгээр багц: Нэвт рашаан амралтын газрын барилгуудын засвар</b></li><li>• <b>Хоёрдугаар багц: Нэвт рашаан амралтын газарт зөөлөн эдлэл, тоног төхөөрөмж нийлүүлэх</b></li></ul>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ  
НЭГДҮГЭЭР БАГЦЫН АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

<b>ШАЛНЫ АЖИЛ</b>			
Д/д	ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ	ХЭМЖИХ НЭГЖ	ТОО ХЭМЖЭЭ
1	Улаан булангийн модон шал шахаж будах	м <sup>2</sup>	216
2	Ажилчдын байрны модон шал тосон будгаар будах	м <sup>2</sup>	120

<b>ДЭЭВРИЙН АЖИЛ</b>			
Д/д	ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН НЭР	ХЭМЖИЖ НЭГЖ	ТОО ХЭМЖЭЭ
1	Улаан булангийн төмөр дээврийн доорхи сараалжин 25% хүртэл шинэ материал оруулж солих	м <sup>2</sup>	24
2	Нийтийн байрны хар гөлтөн төмрөөр хийсэн дээврийн хучилтыг хортойвч ус урсгах хоолойн хамт 25% солих	м <sup>2</sup>	115.2

<b>ХААЛГА ЦОНХНЫ АЖИЛ</b>			
Д/д	ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН НЭР	ХЭМЖИХ НЭГЖ	ТОО ХЭМЖЭЭ
1	Модон хананы хаалга цонхны хайрцаг задалж авах	хайрцаг	4
2	Хананд хаалга угсрах	ш	4

<b>ГЭРЭЛТҮҮЛЭГЧИЙН АЖИЛ</b>			
Д/д	ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ	ХЭМЖИХ НЭГЖ	ТОО ХЭМЖЭЭ
1	Модон хана таазны шавардлага доорх утсыг солих	100м	3
2	Оролтын хувиарлах байгууламж угсрах	ширхэг	2
3	2*2.5мм <sup>2</sup> хүртэл нийлмэл огтлолтой нэг ба олон судастай утас сүвлэх	м	70
4	Гадна зам тайлбайд улайсах чийдэнтэй хамгаалагдсан патрон гэрэлтүүлэгч угсрах	ширхэг	12

<b>БУСАД АЖИЛ</b>			
Д/д	ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ	ХЭМЖИХ НЭГЖ	ТОО ХЭМЖЭЭ
1	Банзаар саравч хийх	м <sup>2</sup>	8
2	Хаяг самбар тогтоох	иж бүрдэл	15
3	Модон жорлон барих	ком	1
4	Гадна талбайд чулуут бетон цутгах	100м <sup>3</sup>	0.3
5	Цементэн зуурмагтай чулуун өрлөгөн хучилттай машины талбай байгуулах	1 талбай	2

## ХОЁРДУГААР БАГЦЫН АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

### ТАВИЛГА, ТҮРГЭН ЭЛЭГДЭХ БАРАА

Д/д	ХИЙХ АЖЛЫН НЭР	ХЭМЖИХ НЭГЖ	ТОО ШИРХЭГ	ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ
1	Үүдний гишгүүр	Ширхэг	26	30см х 20см хивсэнцэр
2	Хогийн сав	Ширхэг	26	хуванцар сав өндөр-60см, өргөн-30см
3	Толь	Ширхэг	15	ханын 60х30
4	Хувцасны өлгүүр	Ширхэг	26	5 гогцоотой төмөр
5	Тумбочка	Ширхэг	50	модон 50см х 60см
6	Узель аппаратур	Ширхэг	2	220V дунд зэрэг
7	Клубын гэрэл	Ширхэг	10	дугуй эргэдэг туузан
8	Угаалгын машин	Ширхэг	2	8 кг-220V хагас автомат
9	Телевиз 42 инч	Ширхэг	1	samsung дүйцэхүйц 42 инч 220V
10	Сандал	Ширхэг	57	модон түшлэгтэй сандлын хөлний өндөр - 40см, тавцан урт- 40 см, өргөн-45 см, түшлэгний өндөр-60 см,
11	Ширээ	Ширхэг	14	мебель 120 см х80 см, ширээний хөлний өндөр - 70 см, тавцан - урт- 130 см, өргөн-80см, өндөр зузаан -4см
12	Халбага дунд	Ширхэг	100	ган /зэвэрдэггүй/
13	Сэрээ дунд	Ширхэг	100	ган /зэвэрдэггүй/
14	Халуун сав том	Ширхэг	14	3 литр
15	Халуун сав жижиг	Ширхэг	26	2 литр
16	Бохирын шугам, материал:			
17	Ø50-100холбогч	М		саарал
18	Ø100-200холбогч	М		саарал
19	Ø100гуравлагч	Ширхэг	40	саарал
20	Ø100булан	Ширхэг	40	саарал
21	Ø100 цонх	Ширхэг	40	саарал
22	100-50 шилжүүлэгч	Ширхэг	40	саарал
23	Үүдний пестбал тохижуулах -Тек - мебель -Мэдээллийн самбар - модон 1,80х1,20 -Галын самбар - модон 80х60 -Хор -Түлхүүрийн хайрцаг - төмөр 60х80 -Цоож түлхүүр			
24	8 ханатай гэр	Ширхэг	1	цоохор иж бүрэн давхаргатай



### ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ

Д.Д	ХИЙХ АЖЛЫН НЭР	ХЭМЖИХ НЭГЖ	ТОО ШИРХЭГ	ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ
1	Орны бүтээлэг	Ширхэг	100	нимгэн давуун 2.20урт-2өргөн
2	Хөшиг	Ширхэг	30	торгон 2,0уртх1,8 өргөн
3	Хөнжил	Ширхэг	50	1 хүний хөвөнтэй урт-2,20, өргөн-1,50
4	Гудас	Ширхэг	65	эсгий урт-2м, өргөн-80см
5	Углаа, дэвсээ	Хос	50	1 хүний даавуун урт-2,20, өргөн-1,50 өнгөн цагаан
6	Дэрний уут /том/	Ширхэг	24	даавуун 80х40 цагаан
7	Дэрний уут /жижиг/	Ширхэг	96	даавуун 50х30 цагаан
8	Дэр /том/	Ширхэг	24	тариатай дэр 80х40
9	Дэр /жижиг/	Ширхэг	96	тариатай дэр 50х30
10	Ширээний бүтээлэг	Ширхэг	20	торгон 1м20х60см цагаан
11	Клубын хөшиг	хүрэн хамбан материалтай, урт 3м, өргөн 4м бүхий 2ш хөшиг		
НИЙТ ДҮН				

### ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

№	БАГАЖНЫ НЭР	ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	ТОО ШИРХЭГ
1	2 -р хоолны тогоо	Марк ЭСК-90-0,47-70, Овор хэмжээ /урт, өргөн, өндөр/: 840х955х950 мм Халах горим /С*/ : 230*С Жин /кг/ : 132 кг Хүчин Чадал /квт/ :12 квт Хүчдэл /v/ : 380В Багтаамж: 70 л	Ш	1
2	1 -р хоолны тогоо	Овор хэмжээ /урт, өргөн, өндөр/: 840х900х1190 мм Халах горим /С*/ : 80 мин 95*С Жин /кг/ : 151 кг Хүчин Чадал /квт/ :18,1 квт Хүчдэл /v/ : 400В - 230 В Багтаамж: 250 литр	Ш	1
3	Шарах тогоо /хуушуур, боорцог, төмс г.м-ийг шарах зориулалт бүхий хөлтэй/	Хүчин чадал: 220 V/3KW Багтаамж: 20 L Шарагчийн хэмжээ: урт/өргөн/өндөр 500х800х250мм-с багагүй Хөлний өндөр 70см-с багагүй	Ш	1

4	Жигнүүр	Бага оврын, 100 - 150 ш гардаг	Ш	1
5	Махны машин	Чадал /квт/ : 1100 W Бүтээмж 220 kg h Хэмжээ /урт, өргөн, өндөр / :470*285*470 Хүчдэл /V/ : 220 V	Ш	1
6	Хоол халуун байлгагч	хэмжээ /урт, өргөн, өндөр / : 880x800x800 Хүчин чадал /квт/ : 1,8 Хүчдэл /v/ : 220	Ш	1
7	Хөргөгч	Нийт багтаамж 230л А зэрэглэлийн цахилгаан зарцуулалттай Цантдаг Доороо хөлдөөгчтэй Хаалгыг 2 талаар нь угсарч болдог Далд бариултай Хэмжээ (УхГхӨ) 55 x 59,4 x 168 см	Ш	1
8	Бэлтгэлийн ширээ	Сайн чанарын даац сайтай тавцантай, гадна тал хүнсний зориулалттай, зэвэрдэггүй ган листээр бүрсэн, хүнсний амт чанарт нөлөөлөхгүй, угааж цэвэрлэхэд хялбар, 4 хөл болон доод тавиурыг зэвэрдэггүй гангаар хийсэн эдэлгээ сайтай. Овор хэмжээ: 1200*700*800мм-с багагүй	Ш	3
9	Ухаалаг шарах шүүгээ	2 хаалгатай, цахилгаан хэрэглээ:220V/380V/50Hz, Цахилгаан зарцуулалт 13.6 квт/цаг, температур 0-400 хэм, тохируулах самбар камер бүрт нэг, 4 тавиур, 2 камертай, овор хэмжээ 124см x 80см x 134см	Ш	1
10	Газын плитка	2 мөлхөө тулгатай	Ш	1
11	Ус буцалгагч	Овор хэмжээ /урт, өргөн, өндөр/ 365x365x630 мм Халах горим /С*/ : 100 С Хүчин Чадал /квт/ : 2 квт Хүчдэл /v/ : 220 В 50Hz Багтаамж: 35 литр	Ш	1
12	Кастрюль	20 - 30 литр багтаамжтай	Ш	2
13	Будаа агшаагч	7,2 литрийн багтаамжтай 2500 ваттын чадалтай Наалддаггүй дотортой Халуунаа барьдаг /5цаг/	Ш	1
		Шарах шүүгээний чадал 2200 Ватт Гриллийн чадал 1200 Ватт		

14	Печь	32 литр багтаамжтай Автоматаар унтардаг /120 минут / Термостат 60-220 С 7 төрлийн горимтой /heatconvection, traditional, grill, gratin, defrost, rotisserie, keep warm / Давхар шилэн хаалгатай Шинэ горим-HEAT CONVECTION” “ GRATIN Хэмжээ 530 х 450 х 340 мм /өргөн х гүн х өндөр/ Жин 14,5 кг	Ш	1
15	Хөлдөөгч	510 литрийн багтаамжтай Дулааныг маш сайн тусгаарладаг Түргэн хөлдөөх горимтой Дотор тал нь зурагдахаас хамгаалагдсан Цахилгаан бага зарцуулах технологтой Аюулгүйн түгжээтэй Сэрүүн хөргөх болон хөлдөөх горимтой Хөргөх температур 0°C - +10°C Хөлдөөх температур -10°C - - 15°C Хурдан хөлдөөх температур - 18°C Хос ажиллагааны тохиргоотой Хэмжээ: 1535 х 740 х 825 мм / өргөн х өргөн х өндөр/	Ш	1
16	Миксер	1 л - ийн багтаамжтай	Ш	1
17	Уур татагч	механик, 100х100см	Ш	1
18	Битүү чанагч	980 Ваттын хүчин байдалтай 6 литрийн багтаажтай Халуунаа барьдаг Битүү чанагч 0-99 минутийн тохиргоотой Эхлэх цагийг 24 цагаар хойшлуулдаг Автомат хоолны цэстэй LCD дэл	Ш	1
19	Хөргүүр буюу аяга таваг ариутгагч	Багтаамж 980л, 220V, цахилгаан зарцуулалт 1800Ватт, тавиур 5 давхар, овор хэмжээ 116*48*168см, халаах температур 120*С	Ш	1
20	Хайруулын таваг	Том, дунд, жижиг	КОМ	1
21	Аяга таваг	цай аяга 50ш 1. 2 - р хоолны тавагнууд, тус бүр100ш салат зуушны тавагнууд 70 ш иж бүрдэлийн таваг 100ш	Ш	

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт /норм, ккал/	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчи йн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
<i>Зөөлөн эдлэл, тоног төхөөрөмж</i>	<i>Техникийн тодорхойлолт од заасны дагуу</i>	<i>Иж бүрнээр нь</i>	-	<i>Ховд аймгийн Дуут сум Нэвт рашаан амралтын газар</i>	<i>2019.04.20</i>	<i>2019.05.01</i>	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### Шалгах болон турших

Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.

### Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт

Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.

### Оюуны өмчийн эрх

Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.

### Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх

Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.

### Баталгаат засварын хугацаа

Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа **[moo]** жил байна.

### Гэрээнд өөрчлөлт оруулах

Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.

### Төлбөр

Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[ГТН-д заасан moo]** хоногийн дотор шуурхай хийнэ.

### Бараа нийлүүлэх хуваарь

Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.

### Алданги оногдуулах

Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.

### Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах

Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.

### Маргааныг шийдвэрлэх

Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **20** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup> 9.1. Алданги оногдуулах хувь: **0.05%**
- Алдангийн нийт дүн:

<sup>2</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.



**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_

(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_

(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_

(Гарын үсэг)

\_\_\_\_\_

(Гарын үсэг)

\_\_\_\_\_

(Албан тушаал)

\_\_\_\_\_

(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;

<sup>3</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>4</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*